



WWF for a living planet®

**Хэрлэн голын усанд тохируулга хийх замаар Говь нутгийг усжуулахаар УИХ-ын нэр бүхий гишүүдийн гаргасан саналын талаар Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газраас баримталж буй байр суурь**

**Улаанбаатар хот. 2007-05-04.**

Сүүлийн жилүүдэд манай орны зарим голуудад далан хаалт барьж ус хуримтлуулах, усны тодорхой хэсгийг Говь нутгийг усжуулах талаар томоохон төслүүдийн санаа мэдээллийн хэрэгслүүдээр цацагдаж, улмаар УИХ-аар хэлэлцэгдэх хүртэл шатанд тавигдаж байна.



Хэрлэн гол, 2007 оны байдал

Тухайлбал, 2007 оны эхээр УИХ-ийн гишүүн Ц.Шаравдорж нарын 6 гишүүн санаачлан **“Сэлэнгэ мөрөн, Онон, Балж голд урсацын тохируулга хийх замаар усны зохих хэсгийг говь, хээрийн бүс рүү шилжүүлэх санал боловсруулах тухай”** УИХ-ын тогтоолын төсөл боловсруулж энэ нь УИХ-д өргөн мэдүүлээд байгаа хууль, бусад шийдвэрийн төслүүдийн жагсаалтанд орсон байна. (Энэ талаар дэлгэрүүлэн УИХ-ын вэб сайтаас “Улсын Их Хуралд өргөн мэдүүлэгдсэн болон хэлэлцүүлгийн шатанд байгаа хууль, бусад шийдвэрийн төслүүд(2007-01-05)” гэсэн хэсгээс үзэж болно. [http://www.parl.gov.mn/detail.php?pid=22&sid=290&table=parl\\_detail&id=6944](http://www.parl.gov.mn/detail.php?pid=22&sid=290&table=parl_detail&id=6944)

Мөн “Өдрийн Сонин”-ий 2007 оны 4 сарын 17-ны дугаарт мэдээлснээр **“Хэрлэн голын урсацад тохируулга хийж, түүний тодорхой хэсгийг говь, хээрийн зарим бүс нутагт шилжүүлэх тухай”** УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын гишүүн Ц.Шаравдорж, Д.Дондог, Ж.Наранцацралт, Д.Тэрбишдагва, Р.Рааш нар санаачилж УИХ-ын дарга Ц.Нямдоржид өргөн барьжээ. Үүнтэй холбогдон Хэрлэн голын асуудал өнөөдөр олон нийтийн анхаарлын төвд ороод байна.

Хэрлэн гол нь Их Хэнтийн нурууны өврөөс эх авч Монгол Улсын нутгаар 1090 км, БНХАУ-ын нутгаар 240 км урсаж Далай нуурт цутгадаг **манай орны хувьд хамгийн урт гол** бөгөөд **“олон улсын гол”** юм. Голын сав газар нь Монгол Улсын 116455 км<sup>2</sup> нутгийг хамардаг байна.

“Хэрлэн-Говь” хэмээх энэхүү төслийн товч танилцуулгад зааснаар Хэрлэн гол дээр 25.5 метрийн өндөртэй 2.56 км урт шороон далан барьж 500 сая м<sup>3</sup> эзэлхүүнтэй хиймэл нуур бий болгоод Хэрлэн голоос 1 секунд тутамд 1.5 м<sup>3</sup> усыг 1.2 метр

голчтой төмөр хоолойгоор авахаар тусгагджээ. Энэхүү төмөр хоолойн урт нь 1042 км байх бөгөөд Чойроор дамжин Цагаансуварга, Оюутолгой, Тавантолгой зэрэг уурхайнуудыг усаар хангаж, улмаар Сайншанд, Замын-үүд, БНХАУ-ын Эрээн хот хүрэхээр төлөвлөгджээ. Мөн, Хэрлэн гол дээр байгуулсан далангаа ашиглан 5 мВт хүчин чадалтай усан цахилгаан станц (УЦС) барих юм байна. Эдгээр байгууламжуудын нийт зардал 294 сая америк доллар хүрэх ажээ.

Энэхүү төслийн талаар Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь Хөтөлбөрийн газар 2003 оноос анхаарлаа хандуулан 2005, 2006 онд 2 удаа төсөл санаачлагч нарт өөрийн байр сууриа илэрхийлсэн албан захиа хүргүүлж байсан бөгөөд энэ удаа олон нийтэд нээлттэйгээр энэхүү байр сууриа дахин илэрхийлж байна.

Үүнд:

1. Хэрлэн гол дээр барих энэхүү байгууламжийн асуудлыг өнөөгийн мөрдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд бүрэн дүүрэн нийцсэн байдлаар тухайлбал, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль”-ийн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай байна. Энэ төслийн асуудлыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэлгүйгээр, олон нийтийн санал бодлыг сайтар сонсолгүйгээр, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үндэс болгон эдийн засаг, нийгэм, байгаль орчны цогц 3 асуудлыг нэгдмэлээр судлан үзэлгүйгээр УИХ-аар яаран хэлэлцүүлэх гэж байгааг зарчмын хувьд буруу хэмээн үзэж байна.
2. Сүүлийн жилүүдэд илтээр мэдрэгдэх болсон уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарлын нөлөө манай орны гол мөрөнд хэрхэн нөлөөлж байгаа талаар хийсэн ултай суурьтай судалгааны ажил өнөө хир алга байна. Иймээс энэ талын судалгааны ажлыг Хэрлэн голын сав газрын хэмжээнд нэн яаралтай эхлүүлэн ирээдүйд 20, 30, 50 жилийн дараа хэрхэн өөрчлөгдөж болохыг нарийвчлан судлах шаардлагатай байна. Хэрлэн голын урсгалыг хааснаар тус голын сав дагуу нэн ялангуяа голын адаг орчмоор оршин амьдарч байгаа нутгийн ард иргэдийн амьжиргаанд хир нөлөөтэй болохыг дээрх судалгаатай уялдуулан цогц байдлаар тодорхойлох нь зүйтэй гэж үзэж байна.

Эцэст нь тэмдэглэхэд, иймэрхүү байдлаар голыг хааж далан байгуулан УЦС барих, улмаар өөр бүс нутгийг усжуулах нь ихээхэн эрсдэлтэй арга хэмжээ байдгийг Арал нуурын ширгэлт гэх мэт дэлхийн гашуун туршлагаадаас харж болно. Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд дээрхи зөвлөмжийг төсөл санаачлагчид болон зохих шатны байгууллагууд анхааран үзэхийг уриалж байна.

***Монголын ус мөрөн нь үеийн үед ариун тунгалаг, хотол олон нь жаргалтай байх болтугай!***

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

СБД, хороо-8, Амарын гудамж-4, Ш/х-115, Улаанбаатар-210620А

Утас: +976-11- 311659, Факс: +976-11-310237, И-мэйл: [info@wwf.mn](mailto:info@wwf.mn) Вэб: [www.wwf.mn](http://www.wwf.mn) , [www.panda.org](http://www.panda.org)